



ОРХОН АЙМГИЙН
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 02/07

Жаргалант

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
хороодын бүрэлдэхүүнийг батлах тухай

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 45-р зүйлийн 45.1, 45.5, 48-р зүйлийн 48.1 дэх хэсгүүд, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан “Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хорооны үйл ажиллагааны журам”-ын 3.1 дүгээр заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороодын бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан 2023 оны 03 дугаар сарын 29-ний ээлжит 10 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Гурав. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангаж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэж, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг хороодод даалгасугай.




ДАРГА

Ш.БИЛГҮҮНБААТАР

6124010053

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 12 сарын 05-ны өдрийн ээлжит
2 хуралдааны 02 дугаар тогтоолын хавсралт



Хороодын бүрэлдэхүүн батлах тухай

- Эрх зүй, нутгийн удирдлага, нийгмийн хөгжлийн хөгжлийн хорооны бүрэлдэхүүн:

- 1. Ж.Алтантөгс
- 2. Т.Лхагвацэрэн
- 3. Д.Нямдаваа
- 4. Э.Сумьяахорол
- 5. Б.Мөнх-Эрдэнэ

- Эдийн засаг, төсөв, санхүүгийн хөгжлийн хорооны бүрэлдэхүүн:

- 1. О.Цэрэндулам
- 2. Э.Пүрэвсүрэн
- 3. Б.Пүрэвсүрэн
- 4. Н.Хадаа
- 5. Д.Төмөрчөдөр

- Дэд бүтэц, байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн хөгжлийн хорооны бүрэлдэхүүн:

- 1. Б.Баттулга
- 2. Ч.Батсуурь
- 3. Г.Хангал
- 4. Р.Эрдэнэ-Очир
- 5. О.Энхтуяа

- Ёс зүй, өргөдөл гомдлын хорооны бүрэлдэхүүн:

- 1. П.Барсболд
- 2. Ж.Дэлхийцэцэг
- 3. Ж.Эрдэнэ-Очир
- 4. Л.Учрал
- 5. Ч.Сувдаа